



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэнгэл сумын эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2026/096/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Өлгий хот

2026 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Ж.Айгүл

Утас: 70422954

Цахим хаяг: aigulj@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930

Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Ахлах аудитор:

Ж.Назгүл

Утас: 99668909

Цахим хаяг: nazgulj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

| | |
|---|----|
| 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 5 |
| 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ | 7 |
| 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 7 |
| 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ | 10 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|-------------|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТБОНӨБАУХАТ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ЭМГ | Эрүүл мэндийн газар |
| ЭМҮЗ | Эрүүл мэндийн үндэсний зөвлөл |

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

ЦЭНГЭЛ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ш.НУРБОЛАТ ТАНАА

2026.02.05 № 180
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Эрүүл мэндийн төвийн тайлант онд зарцуулсан 119.0 сая төгрөгийн тээвэр шатахууны жолоочийн тооцооны хуудсыг санхүүгийн баримтад хавсаргаагүй, 222.7 сая төгрөгийн эмийн зарцуулалтын тайланг зохих журмын дагуу гаргаж тайлагнаагүй, анхан шатны баримтын бүрдүүлэлт, тайлагналд тавих дотоодын хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.6, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийн 14.3.1, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн, 20.1.1, 20.1.4 дэх заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын толилуулга, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

832605000310

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Цэнгэл сумын Эрүүл мэндийн төв нь 2024 онд 5,661.1 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 5,169.9 сая төгрөг зарцуулж, 93 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|------------------------------------|--------------------------------|--------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>417,979,518.31</u> | <u>358,263,665.08</u> |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 226,355.14 | 76,692,310.11 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 226,355.14 | 76,692,310.11 |
| 3121 | Төгрөг | 226,355.14 | 76,692,310.11 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 226,355.14 | 76,692,310.11 |
| 33 | АВЛАГА | 259,141,771.92 | 116,735,834.10 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 580,337.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 259,141,771.92 | 116,155,497.10 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 158,611,391.25 | 164,835,520.87 |
| 351 | Түүхий эд материал | 46,459,190.85 | 42,497,577.97 |
| 35130 | Эм боох материал | 46,459,190.85 | 42,497,577.97 |
| 354 | Хангамжийн материал | 112,152,200.40 | 122,337,942.90 |
| 35420 | Аж ахуйн материал | 102,089,212.90 | 114,649,337.90 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,839,000.00 | - |
| 35460 | Хүнсний материал | 7,223,987.50 | 7,688,605.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>1,299,093,101.79</u> | <u>1,366,222,302.42</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,299,093,101.79 | 1,366,222,302.42 |
| 392 | Биет хөрөнгө | 1,287,725,101.79 | 1,354,854,302.42 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,143,564,247.98 | 1,313,104,400.98 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (206,566,451.28) | (242,507,550.72) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 282,221,990.40 | 282,221,990.40 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (118,508,990.98) | (156,308,240.70) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 396,671,196.58 | 434,359,610.58 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (229,948,506.34) | (299,265,513.54) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 102,321,361.20 | 106,265,167.20 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (82,276,489.77) | (83,262,305.78) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 246,744.00 | 246,744.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 880,645.00 | - |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (880,645.00) | - |
| 393 | Биет бус хөрөнгө | 11,368,000.00 | 11,368,000.00 |
| 39301 | Програм хангамж | 550,000.00 | 550,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (550,000.00) | (550,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 11,368,000.00 | 11,368,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>1,717,072,620.10</u> | <u>1,724,485,967.50</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | <u>67,410,674.50</u> | <u>22,882,712.00</u> |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 67,410,674.50 | 22,882,712.00 |
| 413 | Өглөг | 67,410,674.50 | 22,882,712.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 19,329,509.00 | - |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 12,000,000.00 | 18,166,512.00 |

Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|-------------|---|--------------------------------|--------------------------------|
| 4136 | Бусад өглөг | 36,081,165.50 | 4,716,200.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 36,081,165.50 | 4,716,200.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>1,649,661,945.60</u> | <u>1,701,603,255.50</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,649,661,945.60 | 1,701,603,255.50 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 827,213,180.00 | 827,213,180.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 827,213,180.00 | 827,213,180.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 58,343,908.49 | 110,285,218.39 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 58,343,908.49 | 58,343,908.49 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 51,941,309.90 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 764,104,857.11 | 764,104,857.11 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>1,717,072,620.10</u> | <u>1,724,485,967.50</u> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-------------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 2,495,110,338.93 | 2,836,428,395.35 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 284,940,388.02 | 184,931,036.20 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 284,940,388.02 | 184,931,036.20 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 249,269,909.86 | 181,527,196.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 35,670,478.16 | 3,403,840.20 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,210,169,950.91 | 2,651,497,359.15 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 195,702,338.45 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 192,038,138.45 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 3,664,200.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 85,030,000.00 | 85,286,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 85,030,000.00 | 85,286,300.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 2,125,139,950.91 | 2,370,508,720.70 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 2,125,139,950.91 | 2,370,508,720.70 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2,185,018,092.40 | 2,784,487,085.45 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,185,018,092.40 | 2,784,487,085.45 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,185,005,773.02 | 2,601,197,391.45 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,233,649,090.00 | 1,575,857,604.00 |
| 210101 | Үндсэн цалин | 665,247,866.00 | 751,465,080.75 |
| 210102 | Нэмэгдэл | 488,612,089.00 | 623,698,875.15 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 10,698,000.00 | 56,958,000.00 |
| 210104 | Урамшуулал | 69,091,135.00 | 143,735,648.10 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 157,595,205.00 | 219,417,980.00 |

Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|-------------|---|-----------------------|----------------------|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 105,409,305.00 | 153,996,280.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,046,600.00 | 16,355,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,523,200.00 | 8,177,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,523,200.00 | 8,177,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 26,092,900.00 | 32,710,800.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 77,582,180.62 | 93,697,601.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,505,052.62 | 9,350,729.00 |
| 210302 | Түлш, халаалт | 65,077,128.00 | 78,346,872.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,000,000.00 | 6,000,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 143,070,350.00 | 160,924,975.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,767,850.00 | 8,601,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 101,050,000.00 | 119,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,808,900.00 | 1,667,700.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 6,742,000.00 | 15,655,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 27,701,600.00 | 16,000,675.00 |
| 2105 | Нормативт зардал | 310,595,126.06 | 284,545,571.08 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 243,598,613.56 | 195,735,388.58 |
| 210502 | Хоол, хүнс | 57,213,012.50 | 67,119,182.50 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 9,783,500.00 | 21,691,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 24,753,400.00 | 78,302,150.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 1,115,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 24,753,400.00 | 77,187,150.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,724,000.00 | 7,294,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,724,000.00 | 7,294,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 6,767,625.00 | 3,297,812.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,100,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 412,750.00 | 222,600.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 312,675.00 | 58,812.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 47,100.00 | 50,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,831,100.00 | 2,700,400.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,064,000.00 | 266,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 227,268,796.34 | 177,859,698.37 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 83,714,500.00 | 13,106,253.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 143,554,296.34 | 164,753,445.37 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 12,319.38 | 183,289,694.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | - | 183,186,283.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 44,292,283.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 138,894,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 12,319.38 | 103,411.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 12,319.38 | 103,411.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 310,092,246.53 | 51,941,309.90 |

| | | | |
|---|--------------------------------|------------------------------|-----------------------------|
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>310,092,246.53</u> | <u>51,941,309.90</u> |
|---|--------------------------------|------------------------------|-----------------------------|

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|--------------------------------|--------------------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | <u>1,975,012,113.99</u> | <u>2,794,483,633.97</u> |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,975,012,113.99 | 2,794,483,633.97 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 195,702,338.45 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 192,038,138.45 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 3,664,200.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 85,030,000.00 | 85,286,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 85,030,000.00 | 85,286,300.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 1,889,982,113.99 | 2,513,494,995.52 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,889,982,113.99 | 2,513,494,995.52 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | <u>1,979,998,549.11</u> | <u>2,667,662,229.00</u> |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,979,998,549.11 | 2,667,662,229.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,979,986,229.73 | 2,484,372,535.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,208,833,786.00 | 1,594,575,417.00 |
| 210101 | Үндсэн цалин | 640,432,562.00 | 770,182,893.75 |
| 210102 | Нэмэгдэл | 488,612,089.00 | 623,698,875.15 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 10,698,000.00 | 56,958,000.00 |
| 210104 | Урамшуулал | 69,091,135.00 | 143,735,648.10 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 163,081,000.00 | 218,837,643.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 110,895,100.00 | 153,415,943.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,046,600.00 | 16,355,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,523,200.00 | 8,177,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,523,200.00 | 8,177,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 26,092,900.00 | 32,710,800.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 80,421,180.62 | 72,692,089.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,505,052.62 | 9,350,729.00 |
| 210302 | Түлш, халаалт | 67,916,128.00 | 57,341,360.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,000,000.00 | 6,000,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 142,533,000.00 | 173,923,850.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,627,100.00 | 9,121,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 101,050,000.00 | 119,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,808,900.00 | 1,667,700.00 |

Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|-------------|---|-------------------------------|-------------------------------|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 6,975,300.00 | 12,889,750.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 27,071,700.00 | 31,245,200.00 |
| 2105 | Нормативт зардал | 255,541,688.11 | 307,332,571.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 187,276,488.11 | 222,785,471.00 |
| 210502 | Хоол, хүнс | 58,661,900.00 | 68,377,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 9,603,300.00 | 16,169,300.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 35,268,050.00 | 85,565,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,870,000.00 | 11,708,300.00 |
| 210602 | Тавилга | | 576,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 30,398,050.00 | 73,281,200.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,724,000.00 | 7,294,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,724,000.00 | 7,294,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,686,625.00 | 6,298,412.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 412,750.00 | 222,600.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 312,675.00 | 58,812.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 47,100.00 | 50,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,831,100.00 | 4,870,100.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,083,000.00 | 1,096,900.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 85,896,900.00 | 17,853,053.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 85,896,900.00 | 17,853,053.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 12,319.38 | 183,289,694.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | - | 183,186,283.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 44,292,283.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 138,894,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 12,319.38 | 103,411.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 12,319.38 | 103,411.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>(4,986,435.12)</u> | <u>126,821,404.97</u> |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 24,365,575.00 | 50,355,450.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 24,365,575.00 | 50,355,450.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 24,365,575.00 | 50,355,450.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 24,365,575.00 | 50,355,450.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | <u>(24,365,575.00)</u> | <u>(50,355,450.00)</u> |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | (29,352,010.12) | 76,465,954.97 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 29,578,365.26 | 226,355.14 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 226,355.14 | 76,692,310.11 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|--|---------------------------------|-----------------------|-------------------------|---|
| 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 827,213,180.00 | 764,104,857.11 | (251,748,338.04) | 1,339,569,699.07 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 827,213,180.00 | 764,104,857.11 | (251,748,338.04) | 1,339,569,699.07 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | - |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | - |
| Тайлант үеийн үр дүн | | | 310,092,246.53 | 310,092,246.53 |
| 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 827,213,180.00 | 764,104,857.11 | 58,343,908.49 | 1,649,661,945.60 |
| 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 827,213,180.00 | 764,104,857.11 | 58,343,908.49 | 1,649,661,945.60 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 827,213,180.00 | 764,104,857.11 | 58,343,908.49 | 1,649,661,945.60 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | - |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | - |
| Тайлант үеийн үр дүн | | | 51,941,309.90 | 51,941,309.90 |
| 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 827,213,180.00 | 764,104,857.11 | 110,285,218.39 | 1,701,603,255.50 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|--|-----------------------|------------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 226,355.14 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,768,213,300.00 | 2,718,736,268.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,768,213,300.00 | 2,718,736,268.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,559,373,300.00 | 2,534,727,985.00 |

Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|-------------|---|------------------|------------------|
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,610,456,500.00 | 1,594,575,417.00 |
| 210101 | Үндсэн цалин | 772,182,900.00 | 770,182,893.75 |
| 210102 | Нэмэгдэл | 621,678,000.00 | 623,698,875.15 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 56,958,000.00 | 56,958,000.00 |
| 210104 | Урамшуулал | 159,637,600.00 | 143,735,648.10 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 220,005,400.00 | 218,837,643.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 154,357,800.00 | 153,415,943.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 16,412,000.00 | 16,355,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,205,900.00 | 8,177,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 8,205,900.00 | 8,177,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 32,823,800.00 | 32,710,800.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 75,216,300.00 | 72,692,089.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,000,000.00 | 9,350,729.00 |
| 210302 | Түлш, халаалт | 59,216,300.00 | 57,341,360.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,000,000.00 | 6,000,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 175,799,900.00 | 173,923,850.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 8,997,200.00 | 9,121,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 121,143,800.00 | 119,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,517,500.00 | 1,667,700.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 11,975,300.00 | 12,889,750.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 32,166,100.00 | 31,245,200.00 |
| 2105 | Нормативт зардал | 309,055,200.00 | 307,332,571.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 222,886,800.00 | 222,785,471.00 |
| 210502 | Хоол, хүнс | 68,128,500.00 | 68,377,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 18,039,900.00 | 16,169,300.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 130,554,100.00 | 129,907,550.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 42,958,900.00 | 43,423,500.00 |
| 210602 | Тавилга | 15,000,000.00 | 13,202,850.00 |
| 210604 | Урсгал засвар | 72,595,200.00 | 73,281,200.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 7,512,700.00 | 7,294,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,512,700.00 | 7,294,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 7,151,400.00 | 6,543,412.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 449,000.00 | 222,600.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 320,000.00 | 58,812.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 50,000.00 | 50,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,115,100.00 | 5,115,100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 120,400.00 | |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,096,900.00 | 1,096,900.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 23,621,800.00 | 23,621,453.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 23,621,800.00 | 23,621,453.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 208,840,000.00 | 184,008,283.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 208,840,000.00 | 184,008,283.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 60,556,000.00 | 44,292,283.00 |

| | | | |
|---------------|---|------------------|------------------|
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 148,284,000.00 | 139,716,000.00 |
| 13 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,768,213,300.00 | 2,795,202,222.97 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 87,716,300.00 | 85,286,300.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 87,716,300.00 | 85,286,300.00 |
| 1340 | НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,678,607,300.00 | 2,705,051,722.97 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 2,678,607,300.00 | 2,705,051,722.97 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 1,889,700.00 | 4,864,200.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 3,664,200.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,889,700.00 | 1,200,000.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 226,355.14 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 76,692,310.11 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 52.00 | 53.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 42.00 | 42.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 9.00 | 10.00 |

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулсан алдаа гараагүй.

Аудитаар нийт 460.6 сая төгрөгийн зөрчил илэрч 1.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 116.9 сая төгрөгийн албан шаардлага, 341.7 сая төгрөгийн зөвлөмж өгөв.

3.1 Төлбөрийн акт

Аудитаар 1.9 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоосон.

1. ЭМТ-ийн нэг ажилтанд олгосон 0.5 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг суутгаж аваагүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаж харуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-г “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузал суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.1 “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.2 “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага ” гэсэн заалтуудыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр барагдуулах төлбөрийн акт тогтоов.

2. Журам зөрчиж байгууллагын төрийн үйлчилгээний албан хаагчдад 1.4 сая төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний

албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 3.1-т "Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр барагдуулах төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

Аудитын дүнгээр 116.0 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өгөв. Үүнд:

1.Тайлант онд эмч болон бусад албан хаагч нарт сар бүр илүү цагаар ажилласныг нотлох холбогдох анхан шатны баримтгүйгээр 91.4 сая төгрөгийн илүү цагийн нэмэгдлийг хавтгайруулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 3.1-т "Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

2. Тайлант онд 113 ширхэг 2,980,000 төгрөгийн урт залгуур, 66 ширхэг 1,875,000 төгрөгийн хогийн сав, 930 метр 20,700,000 төгрөгийн хулдаасыг худалдан авч, шууд зарлагдаж төсвийн хөрөнгийн үр ашиггүй, хяналтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчим баримтална", 4.1.3-т "үр ашигтай байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 67.1.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" гэж заасныг тус тус зөрчсөн

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримт бүрдэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд зарцуулсан 119.0 сая төгрөгийн тээвэр шатахууны жолоочийн тооцооны хуудсыг санхүүгийн баримтад хавсаргаагүй, 222.7 сая төгрөгийн эмийн зарцуулалтын тайланг зохих журмын дагуу гаргаж тайлагнаагүй, анхан шатны баримтын бүрдүүлэлт, тайлагналд тавих дотоодын хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-д "Анхан шатны баримтын

үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 14 дүгээр зүйлийн 14.3-д “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ”, 14.3.1-д “анхан шатны баримт бүрдүүлэх”, 20.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогч мэргэжлийн ур чадвар, ёс зүйтэй байх бөгөөд дараах бүрэн эрхтэй байна”, 20.1.1-д “нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах”, 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

1.1. Өгсөн зөвлөмж:

Тээвэр шатахууны болон эмийн зарцуулалтын анхан шатны баримтын бүрдүүлэлтийг бүрэн хангаж, дотоодын хяналтыг сайжруулж, хууль журмыг мөрдөж ажиллах;

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш **30 хоногийн дотор**, зөвлөмжийн биелэлтийг **2026 оны 09 дүгээр сарын 01-ны өдрийн дотор** Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | | |
|-------------------|------------|-----|-----------------------------------|-----|--------------------------|-----|------------|-----|--------------|-----|---------|-----|--|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | | Тоо | Дүн | |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | | |
| | | | | | | - | - | - | - | - | - | | |
| ДҮН | | | | | | - | - | - | - | - | - | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | | |
|--|-------------|------------------|---------------|----------------|-----------------|------------------|----------|------------------|--------------------------------------|----------|---|----------|----------|
| | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | | |
| | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | |
| Цалингийн урьдчилгааг суутгаж аваагүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаж харуулаагүй | 1 | 500.0 | 1 | 500.0 | - | - | - | - | - | - | - | - | - |
| Журам зөрчиж байгууллагын төрийн үйлчилгээний албан хаагчдад илүү цагийн нэмэгдэл хөлс олгосон | 1 | 1,364.9 | 1 | 1,364.9 | | | | | | | | | |
| Эмч нарт хавтгайруулан сар бүр илүү цагаар ажилласныг нотлох холбогдох анхан шатны баримтгүйгээр илүү цагийн нэмэгдэл олгосон. | 1 | 91,412.2 | | | 1 | 91,412.2 | | | | | | | |
| Тайлант онд нийт 25.5 сая төгрөгийн худалдаж авсан бараа материалыг шууд зарлагдаж үргүй зардал гаргасан | 1 | 25,548.0 | | | 1 | 25,548.0 | | | | | | | |
| Тээвэр шатахуун болон эмийн зарцуулалтын тайланг зохих нурмын дагуу гаргаж тайлагнаагүй | 1 | 341,785.5 | | | | | 1 | 341,785.5 | | | | | |
| ДҮН | 5 | 460,610.6 | 2 | 1,864.9 | 2 | 116,960.2 | 1 | 341,785.5 | - | - | - | - | - |